**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дашбалбар сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/31/СТА-ТШЗ***

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга<br>бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Аудитор: Э.Нандинчимэг<br>Утас: 7000-3775 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ЗТХС | Зам тээвэр хөгжлийн сайд |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ...3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан...5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ...5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан...7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ...8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ...9
3.Аудитын тайлан...10
3.1. Ерөнхий зүйл...10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ...10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт ...10
3.4. Материаллаг байдал ...10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ...11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ...11
3.7. Шилэн дансны мэдээлэл...12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...12
3.9. Аудитын илрүүлэлт...12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ...12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ...13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ...14

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Т.АМГАЛАН ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 298

танай__________-ны №__________-т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Дашбалбар сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Дашбалбар сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Дашбалбар сумын соёлын төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 90 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020278

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **57,246,237.77** | **58,224,871.19** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 57,246,237.77 | 58,224,871.19 |
| **354** | **Хангамжийн материал** | 57,246,237.77 | 58,224,871.19 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 44,000.00 | 44,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 56,378,437.77 | 57,357,071.19 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 823,800.00 | 823,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **310,591,231.69** | **317,591,964.61** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 310,591,231.69 | 317,591,964.61 |
| **392** | **Биет хөрөнгө** | 297,575,231.69 | 304,575,964.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 291,501,626.18 | 291,501,626.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (12,909,933.24) | (25,899,866.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 53,924,278.00 | 79,171,002.31 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (46,334,569.99) | (50,481,200.42) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,717,742.00 | 10,717,742.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,752,297.02) | (8,606,299.78) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,163,400.00 | 1,163,400.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (581,700.00) | (727,125.00) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,050,626.00 | 1,050,626.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,117,000.00 | 5,117,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,660,000.24) | (4,770,000.28) |
| 39217 | Ном | 6,339,060.00 | 6,339,060.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,016,000.00 | 13,016,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,016,000.00 | 13,016,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **367,837,469.46** | **375,816,835.80** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **367,837,469.46** | **375,816,835.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 367,837,469.46 | 375,816,835.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 96,367,371.00 | 96,367,371.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 96,367,371.00 | 96,367,371.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 72,887,848.97 | 80,867,215.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 72,887,848.97 | 72,887,848.97 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 7,979,366.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 198,582,249.49 | 198,582,249.49 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **367,837,469.46** | **375,816,835.80** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **71,956,800.00** | **114,322,657.73** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **68,929,300.00** | **113,310,457.73** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 2,138,200.00 | 25,840,357.73 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,138,200.00 | 6,108,636.73 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,138,200.00 | 6,108,636.73 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | | 19,731,721.00 |
| 123 | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 66,791,100.00 | 87,470,100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 66,791,100.00 | 87,470,100.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,027,500.00** | **1,012,200.00** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,027,500.00 | 1,012,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,027,500.00 | 712,200.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **87,514,489.73** | **106,343,291.39** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **87,514,489.73** | **106,343,291.39** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 86,513,753.99 | 105,378,135.78 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 48,939,575.00 | 68,149,404.00 |
| 210101 | Үндсэн цалин | 41,678,433.00 | 57,777,123.78 |
| 210104 | Урамшуулал | 179,000.00 | 1,838,176.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,082,142.00 | 8,534,104.22 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,778,121.66 | 8,938,686.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,649,721.66 | 6,078,310.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,000.00 | 715,094.07 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 421,100.00 | 572,075.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 105,200.00 | 143,018.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,052,100.00 | 1,430,188.14 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,948,106.00 | 4,311,989.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,335,726.00 | 1,428,048.57 |
| 210302 | Түлш, халаалт | 1,612,380.00 | 2,573,640.87 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 310,300.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 5,094,461.60 | 5,000,468.16 |
| 210401 | Бичиг хэрэг | 166,000.00 | 205,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,463,461.60 | 4,479,768.16 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 240,000.00 | 200,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 58,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 65,000.00 | 56,500.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 200,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | - |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 783,800.00 | 243,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 783,800.00 | 243,400.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 300,000.00 | 63,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 63,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,941,900.00 | 425,196.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,775,600.00 | 150,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 270,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,300.00 | 5,196.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,527,789.73 | 18,245,991.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 176,200.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,351,589.73 | 18,245,991.39 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,735.74 | 965,155.61 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 240,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 240,000.00 | 300,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 760,735.74 | 665,155.61 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 760,735.74 | 665,155.61 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(15,557,689.73)** | **7,979,366.34** |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(15,557,689.73)** | **7,979,366.34** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **69,818,600.00** | **88,482,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **66,791,100.00** | **87,470,100.00** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 66,791,100.00 | 87,470,100.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 66,791,100.00 | 87,470,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,027,500.00** | **1,012,200.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,027,500.00 | 1,012,200.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | 3,027,500.00 | 712,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **69,180,700.00** | **88,482,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **69,180,700.00** | **88,482,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **68,179,964.26** | **87,517,144.39** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 48,939,575.00 | 68,103,918.68 |
| 210101 | Үндсэн цалин | 41,678,433.00 | 57,777,123.78 |
| 210104 | Урамшуулал | 179,000.00 | 1,838,176.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,082,142.00 | 8,488,618.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,778,121.66 | 8,984,172.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,649,721.66 | 6,109,244.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,000.00 | 718,731.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 421,100.00 | 574,984.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 105,200.00 | 143,744.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,052,100.00 | 1,437,467.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 2,948,106.00 | 3,486,512.57 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,335,726.00 | 1,428,048.57 |
| 210302 | Түлш, халаалт | 1,612,380.00 | 1,748,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 310,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,138,461.60 | 5,825,945.03 |
| 210401 | Бичиг хэрэг | 400,000.00 | 205,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,463,461.60 | 5,305,245.03 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 | 200,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 58,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 65,000.00 | 56,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 783,800.00 | 243,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 783,800.00 | 243,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 300,000.00 | 63,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 63,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,091,900.00 | 425,196.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,925,600.00 | 150,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 270,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,300.00 | 5,196.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 385,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 385,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,000,735.74** | **965,155.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 240,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 240,000.00 | 300,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 760,735.74 | 665,155.61 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 760,735.74 | 665,155.61 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **637,900.00** | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **637,900.00** | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **637,900.00** | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 637,900.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 637,900.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(637,900.00)** | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 96,367,371.00 | 198,582,249.49 | 72,887,848.97 | 0.00 | 367,837,469.46 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **96,367,371.00** | **198,582,249.49** | **72,887,848.97** | **0.00** | **367,837,469.46** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,367,371.00** | **198,582,249.49** | **72,887,848.97** | **0.00** | **367,837,469.46** |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **96,367,371.00** | **198,582,249.49** | **72,887,848.97** | **0.00** | **367,837,469.46** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **96,367,371.00** | **198,582,249.49** | **72,887,848.97** | **0.00** | **367,837,469.46** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 7,979,366.34 | 0.00 | 7,979,366.34 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,367,371.00** | **198,582,249.49** | **80,867,215.31** | **0.00** | **375,816,835.80** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,477,900.00 | 86,804,944.39 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,477,900.00 | 86,804,944.39 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,177,900.00 | 86,504,944.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 49,417,300.00 | 48,760,575.00 | 68,162,900.00 | 68,103,918.68 |
| 210101 | Үндсэн цалин | 42,272,300.00 | 41,678,433.00 | 57,835,800.00 | 57,777,123.78 |
| 210104 | Урамшуулал | - | - | 1,838,200.00 | 1,838,176.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,145,000.00 | 7,082,142.00 | 8,488,900.00 | 8,488,618.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,790,500.00 | 6,778,121.66 | 9,080,500.00 | 8,984,172.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,662,100.00 | 4,649,721.66 | 6,384,300.00 | 6,109,244.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,000.00 | 550,000.00 | 672,000.00 | 718,731.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 421,100.00 | 421,100.00 | 549,900.00 | 574,984.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 105,200.00 | 105,200.00 | 130,100.00 | 143,744.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,052,100.00 | 1,052,100.00 | 1,344,200.00 | 1,437,467.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,040,000.00 | 2,948,106.00 | 3,897,900.00 | 3,486,512.57 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,500,000.00 | 1,335,726.00 | 1,500,100.00 | 1,428,048.57 |
| 210302 | Түлш, халаалт | 1,540,000.00 | 1,612,380.00 | 1,848,000.00 | 1,748,164.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - | 549,800.00 | 310,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,093,600.00 | 5,093,461.60 | 5,631,100.00 | 5,525,945.03 |
| 210401 | Бичиг хэрэг | 150,000.00 | 400,000.00 | 63,200.00 | 61,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,463,600.00 | 4,463,461.60 | 5,152,600.00 | 5,149,445.03 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 50,000.00 | 200,000.00 | 200,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 | 58,800.00 | 58,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 60,000.00 | 100,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | - | 56,500.00 | 56,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.00 | 200,000.00 | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 200,000.00 | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 783,800.00 | 783,800.00 | 66,200.00 | 66,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 783,800.00 | 783,800.00 | 66,200.00 | 66,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 300,000.00 | 300,000.00 | 63,000.00 | 63,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 300,000.00 | 300,000.00 | 63,000.00 | 63,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 166,300.00 | 166,300.00 | 276,300.00 | 275,196.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 160,000.00 | 270,000.00 | 270,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,300.00 | 6,300.00 | 6,300.00 | 5,196.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 300,000.00 | 300,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 300,000.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | 300,000.00 | 300,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,477,900.00 | 86,804,944.39 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,477,900.00 | 87,470,100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 66,791,500.00 | 66,030,364.26 | 87,477,900.00 | 87,470,100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **1,012,200.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **1,012,200.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 1,012,200.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 300,000.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | - | 144,200.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 155,800.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 177,200.00 | |
| 210604 | Урсгал засвар | - | 177,200.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 150,000.00 | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 150,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 385,000.00 | |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 385,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 1,012,200.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,012,200.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 300,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 712,200.00 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашбалбар сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25–ы хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дашбалбар сумын Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 7 зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Ковид 19 халдварт өвчинтэй холбоотой зарим ажил хэрэгжих боломжгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дашбалбар сумын Соёлын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дашбалбар сумын Соёлын төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 106,343.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 2,126.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дашбалбар сумын Соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,979.3 мянган төгрөгөөр буюу 1.02 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 57,246.2 | 58,224.8 | 978.6 |
| Үндсэн хөрөнгө | 382,829.7 | 408,076.5 | 25,246.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (72,238.5) | (90,484.5) | (18,246.0) |
| **Нийт хөрөнгө** | **367,837.4** | **375,816.8** | **7,979.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 367,837.5 | 375,816.8 | 7,979.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **367,837.4** | **375,816.8** | **7,979.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 58,224.8 мянган төгрөг болж 978.6 мянган төгрөгөөр өссөн нь БСУГ-аас хөгжмийн дагалдах хэрэгслийг хандиваар хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 408,076.5 мянган төгрөг болж 25,246.7 мянган төгрөгөөр өссөн нь БСУГ-аас халаалтын тогоо болон тоног төхөөрөмж хандивласантай холбоотой нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Дашбалбар сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 42,365.9 мянган төгрөгөөр буюу 37.1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 18,828.8 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 87,477.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 87,477.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн санхүүжилтийг 87,477.9 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 87,477.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 87,470.1 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 87,470.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 87,470.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 86,804.9 мянган төгрөгийг зарцуулж 665.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 88,482.3 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 77,088.1 мянган төгрөг буюу 87.1 хувийг эзэлж байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өөрийн үйл ажиллагаанаас 1,012.2 мянган төгрөгийн орлого орсон байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 4 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 6,624.5 мянган төгрөгийн гүйлгээ, бүтэн жилээр батлагдсан төсөв 89,508.5 мянган төгрөгийн мэдээлэл нийт 96,133.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,224.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27,224.0 мянган төгрөгийн зөрчилд 236.1 мянган төгрөгийн 1 акт тогтоож, 26,987.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 27,224.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 236.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 26,987.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 236.1 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Тайлант оны эцэст үндсэн хөрөнгийн тооллого нь дэлгэрэнгүй бүртгэл дэх дүнгээс 26,686.0 мянган төгрөгөөр дутуу хийсэн ба тооллогын бүртгэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант хугацаанд гарсан зардлаас 301.9 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2021.02.25 | ***Дорнод аймгийн Дашбалбар сумын соёлын төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ДОА-2021/31/СТА-ТШ3 |

| Шалгагдсан байгууллагын нэр: | **Дорнод аймгийн Дашбалбар сумын Соёлын төв** | Мянган төгрөг |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Үндсэн хөрөнгийн тооллогын 26,686.0 мянган төгрөгөөр дутуу хийсэн бөгөөд тооллогын бүртгэл хангалтгүй байна. | 26,686.0 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Амгалан Д.Нандинжаргал |
| 2 | Нийт 139 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр) 89,508.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр) 6,624.5 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Сар бүр) 1 мэдээлэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр 4 сард) 1 мэдээлэл тус тус хугацаа хоцорч байршуулсан байна. | 0.0 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Амгалан Д.Нандинжаргал |
| 3 | МОНГОЛ ШУУДАН руу харилцахаас 58.8 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд цахим төлбөрийн систем баримт шивэгдээгүй байна. Мөн Найнги ХХК руу 1,123.8 мянган төгрөг шилжүүлсэн ба цахим төлбөрийн баримтад 880.7 мянган төгрөг шивэгдсэн байна. Нийт 301.9 мянган төгрөгийн зардал цахим төлбөрийн баримтад шивэгдээгүй байна.. | 301.9 | Албан шаардлага өгөх | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Амгалан Д.Нандинжаргал |
| 4 | Батлагдсан төсөв 5,152.6 /нүүрс тээврийн хөлс багтсан/ мянган төгрөг бөгөөд ЕЖ шатахууны зардалд төлсөн мөнгөн дүнг АШБ-тай тулган жишиг нормоор тооцоолоход 236.1 мянган төгрөгийн илүү зарцуулсан байна. | 236.1 | Төлбөрийн акт тогтоох | СТ-ийн эрхлэгч Нягтлан бодогч | Т.Амгалан Д.Нандинжаргал |
| | **ДҮН** | **27,224.0** | | | |